

## **Нягтлан бодох бүртгэлийн судалгааны хөгжил, хандлага**

*Д. Баттуяа*<sup>1</sup>

Хураангуй

Нийгэм эдийн засгийн хөгжлийг дагалдан Нягтлан бодох бүртгэл (НББ) тасралтгүй хөгжиж, НББ-ийн судалгаа, түүний арга зүй улам өргөжин тэлсээр байна. Өгүүллийн зорилго нь НББ-ийн судалгааны хөгжил, хандлагыг шинжлэн НББ-ийн чиглэлээр бичсэн судалгааны зарим өгүүлэлд дүн шинжилгээ хийж, НББ-ийн судалгаанд хамрагдаж буй нийтлэг сэдвүүд, судалгааны арга зүйн талаар дүгнэлт өгөхөд оршино.

*Түлхүүр үгс:* НББ-ийн судалгаа, судалгааны арга зүй

Оршил

Аливаа боловсрол тасралтгүй үргэлжлэн хөгжих үндэс нь судалгаа байдаг. Судалгаа нь тухайн юмс үзэгдлийн өөрчлөлтийн зүй тогтлыг түүнд нөлөөлөх хүчин зүйлсээр судалж, чиг хандлагыг тодорхойлон, дүгнэлт, зөвлөмж гаргах зорилго бүхий үйл ажиллагаа бөгөөд энэ нь ойлгомжтой, бодитой, уялдаатай байхыг шаарддаг. НББ-ийн судалгаа нь цаг хугацааны явцад байнга өөрчлөгдсөөр байгаагаас түүнийг тодорхойлж дүгнэхэд амар биш. Юун түрүүнд судалгааг ойлгох нь судалгааны хөгжил, хандлагыг ойлгохоос эхэлдэг. Энэ талаар эрдэмтдийн бичсэн ажлуудаас харахад НББ-ийн судалгаа ч өөрийн онцлог шинж чанартай хөгжиж ирсэн ажээ.

НББ-ийн судалгааны хөгжил, хандлага

Орчин үед эрдэмтэд НББ-ийн судалгааны арга зүйг норматив (normative) болон позитив (positive) судалгаанд хувааж үзэж байна. Норматив судалгааны үр дүнд нягтлан бодох бүртгэлийн хамгийн сайн стандарт, зарчмыг санал болгох, тодорхойлох зорилготой бол позитив судалгаа нь НББ-ийн практикыг тайлбарлах болон НББ-ийн үйл ажиллагааг холбогдох онолд суурилан урьдчилан таамаглах, түүнийгээ батлах зорилготой академик судалгааны салбар юм. 1960-аад оноос өмнө НББ-ийн судалгаа нь ихэнхидээ норматив хандлагатай (өөрөөр хэлбэл, ямар байх ёстой гэдгийг тодорхойлоход чиглэдэг) байсан гэж үздэг. НББ-ийн судалгаанд Болл, Браун нарын 1968 онд бичсэн хувьцааны үнэ болон НББ-ээрх ашгийн хоорондын хамаарлыг хэмжсэн судалгааны ажил нь өмнөх

---

<sup>1</sup> МУИС-ийн Бизнесийн Сургуулийн НББ-ийн тэнхимийн багш, доктор.  
E-mail: battuya.d@num.edu.mn

судалгааны арга зүйгээс шинэлэг болсоноороо НББ, санхүүгийн судалгааны арга зүйд ихээхэн өөрчлөлтийг авчирсан гэж үздэг. Уг судалгааны зорилго нь хувьцаат компанийн хувьцааны хэвийн бус өгөөжийг тооцож түүнд үндэслэн хувьцааны үнэ болон компанийн ашгийн хоорондын хамаарлыг хэмжсэн байдаг. Энэ арга зүй, өөрөөр хэлбэл санхүүгийн шинжлэх ухааны онол, тухайлбал, үр ашигтай зах зээлийн таамаглалын онолд суурилан таамаглал дэвшүүлж, түүнийг их хэмжээний өгөгдөл дээр статистик дүн шинжилгээ хийж шалгах, таамаглалаа батлах зэрэг ерөнхий арга зүй нь тэр үеийн НББ-ийн чиглэлийн сэтгүүлүүдэд хэвлэгдсэн судалгаануудад зонхилох хандлагатай болж ирсэн байна. Энэ хандлага нь позитив (байх ёстой гэж тодорхойлохоос илүү бодит өгөгдлийг тайлбарлах, шалгах) судалгааны арга зүйд шилжсэн гэж үздэг. Энэ позитив хандлага нь тухайн үед нэлээн шүүмжлэлд өртөж байсан ч өнөөдрийг хүртэл мэргэжлийн олон сэтгүүлүүдэд хэвлэгдсэн судалгаануудад ихээхэн ашиглагдсаар байгааг эрдэмтэд онцолсон байна.

1970-аад оны сүүлээс дэлхий дахинд НББ-ийн судалгаа эрчимтэй хөгжиж эхэлсэн бөгөөд энэ үед НББ-ийн судалгааны асуудалд санхүүгийн эдийн засгийн онолын хэрэглээ илүү нэмэгдэж, холбогдох судалгааны арга, арга зүй түлхүү хэрэглэгдэх болсон байна. Гэвч энэ нь багагүй шүүмжлэлийг дагуулсаар байжээ. 1979 онд Америкийн нягтлан бодогчдын олон улсын холбооноос гаргасан “НББ-ийн эмпирик судалгаа”-ны тайланд НББ-ийн судалгаанд идеализм<sup>2</sup> урсгал зонхилж байгааг онцолж, улмаар нийгмийн шинжлэх ухааны онолыг ашиглахаас гадна зарим судалгаанд байгалийн шинжлэх ухааны онолыг ашиглах хандлага ч нэмэгдэж байгаа талаар тэмдэглэсэн байна. Улмаар НББ-ийн судалгаа нь математик загваруудад суурилан санхүүгийн тайлан, хувьцааны үнийн мэдээлэлд үндэслэн судалгаа, туршилт хийх, математик тооцоолуудыг хийж таамаглалаа батлах, загварчлах хандлагатай болж хөгжиж байна.

Дэлхий дахинд НББ-ийн судалгааны хөгжил, арга зүйн талаар бичсэн эрдэм шинжилгээний өгүүлүүд олон байгаа ч манай улсын тохиолдолд харьцангуй ховор юм. Харин НББ-ийн түүхэн хөгжил, өнөөгийн байдлын талаар бичсэн ажлууд нилээд байна. НББ-ийн судалгааны талаар судалсан гадны судалгааны ажлуудад тухайлбал:

Олер болон Скүүз (2009) нар НББ-ийн судалгаанууд, түүнд ашиглагдаж байгаа судалгааны арга зүйд дүгнэлт хийж НББ-ийн судалгааг тодорхойлох оролдлого хийсэн байна. Тэд НББ-ийн зургаан мэргэжлийн шилдэг сэтгүүлд хэвлэгдсэн өгүүлүүдийн сэдвүүд, судалгааны арга зүй, ишлэлүүдэд үндэслэн НББ-ийн судалгааг тодорхойлсон ба энэ нь санхүүгийн мэдээллийг тайлагнах, шалгах, дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх үйл явцад эдийн засгийн үйл явдлын нөлөө болон эдийн засгийн үйл явдалд мэдээллийн нөлөөний талаарх судалгаа юм гэж дүгнэжээ. Үүнээс харахад НББ-ийн судалгааг санхүүгийн мэдээллийг боловсруулах үйл явцад үзүүлэх эдийн засгийн үйл явдлын нөлөө гэж ойлгож болохоор байна. НББ-ийн академик судалгаанд зонхилж буй сэдвүүдийг Койн, Саммерс, Уильямс, Вүүд (2010) нар НББ-ийн төрлөөр нь судалсан байна. Үүнийг доор товч харуулбал:

<sup>2</sup> Идеализм гэдэг нь ертөнцийн талаарх танин мэдэхүйн үзэл бөгөөд ертөнц дээрх бүх зүйл нь бидний оюун ухаантай хамааралтай гэж үздэг үзэл юм.

- *НББ-ийн мэдээллийн систем (НББМС)*: НББМС-ийн судалгаанд бүртгэлийн мэдээллийг үүсгэх, цуглуулах, хадгалах системүүдийн хэрэглэгчид болон тухайн системүүдийн холбоотой асуудлуудыг судалдаг. НББМС нь цахим эсвэл цахим бус хэлбэртэй байх ба судалгаа нь шинжлэх ухааны загварчлал, танин мэдэхүйн ойлголт түүнийг шалгах, системүүдийг шинжлэх, шийдвэрийн туслахууд, системийн дэмжих, системийн баталгааг боловсруулах, аюулгүй байдал, хяналт, системийн ашиглалтын шинж байдал болон системийн гүйцэтгэл зэргийг судалж байна.
- *Аудит*: Аудитын судалгаанд аудитын орчины талаарх судалгаа - гадаад, дотоод орчин; аудиторын шийдвэр гаргалт; аудиторын бие даасан байдал; санхүүгийн тайлагналын үйл явцад аудитын үр нөлөө, төлбөр, аудитын мэргэшсэн байдал, аудитын чанар зэргийг түлхүү судалж байна.
- *Санхүүгийн бүртгэлийн судалгаа*: Үүнд санхүүгийн бүртгэлийн сэдвээс гадна санхүүгийн бүртгэлийн мэдээлэл дээр үндэслэн шийдвэр гаргалт болон хөрөнгийн зах зээлийн талаарх судалгаанууд зонхилдог. Тухайлбал: санхүүгийн тайлагналын судалгаа, хөрөнгийн зах зээлийн судалгаа гэх мэт.
- *Удирдлагын бүртгэлийн судалгаа*: Энэ судалгаанд байгууллага доторх нөөцийн хуваарилалт, урамшуулал, шийдвэр гаргалт, нөхөн төлбөр, төсөвлөлттэй холбоотой асуудлуудыг судалж байна.
- *Татвар*: Албан татвар төлөгчийн шийдвэр гаргалт, татварын хуваарилалт, татварын тооцоолол, татварын зорилгод нийцүүлэн НББ-ийн ажил гүйлгээг бүртгэх, зохион байгуулах, татварын урамшуулал болон татварын тайлагналд зах зээлийн хариу үйлдэл зэрэг асуудлуудыг судалдаг. Тухайлбал: татварын судалгааны ерөнхий хандлага, орлогын татварын бүртгэлийн судалгаа, корпорацийн санхүү, татвар ногдуулалтын талаарх судалгаа, татварын судалгааны ирээдүйн чиг хандлага - эдийн засгийн төлөв байдал зэргийг судалж байна.
- *Бусад*: Дээрхээс бусад НББ-тэй холбоотой асуудлууд, тухайлбал, НББ-ийн боловсрол, НББ-ийн судалгааны арга зүй, НББ-ийн хууль эрх зүй, сэтгэл судлал, НББ-ийн түүх, НББ-ийн мэргэжил, ажлын орчин гэх мэт сэдвүүдийг хамарсан байна.

Дээрх судалгаанаас харахад санхүүгийн бүртгэлийн хувьд тайлагнал, түүний процесс ба эдийн засгийн үйл явдлын нөлөө, аудитын хувьд санхүүгийн тайлагнал ба аудитын харилцан хамаарал, удирдлагын бүртгэлийн хувьд шийдвэр гаргалттай холбоотой удирдлагын бүртгэл болон менежментийн онолын арга аргачлал, тэдгээрийн хэрэгжилт, үр нөлөөг судалдаг нь харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд НББ, тайлагналын ирээдүйд учирч болох асуудлуудыг судалж түүнд хариу үйлдэл юу болохыг урьдчилан таамаглах, түүнийг шийдвэрлэхэд тус дөхөм болох талаас мөн судалсан ажлууд нилээд нэмэгдэж байна. Судалгааны арга зүйн хувьд сайн томъёолсон онол буюу математик загвар бүхий судалгааны ажлууд, онолын хувьд хамаарагч болон үл хамааран хувьсагч хүчин зүйлүүдийн хоорондын харилцааг илэрхийлэх таамаглалыг дэвшүүлж, түүнийг батласнаар тайлбарлах, өгөгдөл цуглуулах, математик, статистикийн аргуудаар дамжуулан өгөгдлийг шинжилснээр үр дүн, дүгнэлтээ гаргах энэ хэлбэр нь НББ-ийн судалгаанд зонхилсоор байна.

## Дүгнэлт

Дэлхий дахинд НББ-ийн судалгаа нь ерөнхийдөө 1960-аад оноос өмнө норматив хандлагатай байсан бөгөөд 1970-аад оны сүүлээс НББ-ийн судалгааны асуудалд санхүүгийн эдийн засгийн онолын хэрэглээ улам нэмэгдэж, судалгааны арга зүйн хувьд позитив хандлагатай болж ирсэн байна. Энэ хандлага тухайн үедээ нилээн шүүмжлүүлж байсан ч өнөөг хүртэл НББ-ийн судалгаанд өргөн ашиглагдсаар улам хөгжсөөр иржээ. Улмаар НББ-ийн судалгаанд шинжлэх ухааны сайн томъёолсон онол буюу математик загвар санал болгосон судалгааны арга зүй болон хамаарагч болон үл хамааран хувьсагч хүчин зүйлүүдийн хоорондын харилцааг илэрхийлсэн таамаглалыг дэвшүүлж, түүнийг батлаж тайлбарлах хандлага зонхилж байна.

## Ашигласан материал

1. Oler, D., Oler, M., Skousen, C. J. (2010). Characterizing Accounting Research, *Accounting Horizons*, 24(4), 635–670.
2. Gordon, T. P., Porter, J. C. (2009). Reading and Understanding Academic Research in Accounting: A Guide for Students, *Global Perspectives on Accounting Education*, 6, 25-45.
3. Coyne, J. G., Summers, S. L., Williams, B., Wood, D. (2010). Accounting Program Research Rankings by Topical Area and Methodology, *Issues in Accounting Education*, 25(4), 631–654.
4. Ball, R., Brown, P. (1968). An Empirical Evaluation of Accounting Income Numbers, *Journal of Accounting Research*, 6(2), 159-178.
5. Watts, R. L., Zimmerman, J. L. (1978). Towards a Positive Theory of the Determination of Accounting Standards, *Accounting Review*, 53(1), 112-134.